



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/21/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn Аудитор Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ /Эх хувь/ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	15
3.5.2 Авлага .....	15
3.5.3 Урьдчилгаа .....	16
3.5.6 Бараа материал .....	16
3.5.7 Үндсэн хөрөнгө .....	17
3.5.8 Өр төлбөр.....	17
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5.10 Орлогын данс.....	18
3.5.11 Зардлын данс.....	18
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.7 Шилэн дансны мэдээлэл .....	21
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	22
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	23
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	23
4. Менежментийн захидал .....	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ҮОМШӨД	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГМИЙН Г  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
Д.МӨНХБАТ ТАНАА

2021.03.25 № 2184

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

• 005020255

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,681,336.99</u></b>	<b><u>9,678,862.63</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,228,594.36	5,839,357.78
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2,228,594.36	5,839,357.78
31211	Төрийн сангийн харилцах	2,922.02	1,172.02
31213	Арилжааны банк дахь харилцах	2,225,672.35	5,838,185.76
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	431,577.31	3,823,794.75
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	393,889.99	448,573.75
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	3,302,483.01
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	37,687.32	72,737.99
3351	Байгууллагаас авах авлага	33,776.42	68,827.09
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,910.90	3,910.90
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	350.46	-
34600	Урьдчилж гарсан зардал	350.46	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	20,814.85	15,710.11
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,814.85	15,710.11
35410	Бичиг хэргийн материал	966.80	446.60
35420	Аж ахуйн материал	8,668.63	9,593.13
35430	Сэлбэг хэрэгсэл	4,232.60	1,968.05
35470	Бусад хангамжийн материал	6,946.82	3,702.33
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>428,233.46</u></b>	<b><u>197,796.92</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	428,233.46	197,796.92
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	361,008.46	130,571.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	466,812.10	466,812.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(212,425.96)	(424,851.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,980.00	89,980.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,987.78)	(69,984.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,603.30	141,764.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,196.50)	(100,987.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,856.00	63,466.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,632.71)	(35,628.05)

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

393	<b>Биет бус хөрөнгө</b>	67,225.00	67,225.00
39301	Програм хангамж	3,700.60	3,700.60
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,700.60)	(3,700.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,225.00	67,225.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,109,570.45</b>	<b>9,876,659.55</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>276,844.69</b>	<b>491,032.47</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	276,844.69	491,032.47
<b>413</b>	<b>Өглөг</b>	121,654.43	63,153.71
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	121,180.37	63,153.71
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	474.06	-
41361	Байгууллагад төлөх өглөг	320.91	-
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	153.15	-
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	155,190.26	427,878.77
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	155,190.26	427,878.77
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,832,725.76</b>	<b>9,385,627.08</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,832,725.76	9,385,627.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320,944.66	320,944.66
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,292,326.39	8,845,227.71
51210	Өмнөх үеийн үр дүн	1,191,992.50	2,298,276.87
51220	Тайлант үеийн үр дүн	1,100,333.88	6,546,950.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,454.71	219,454.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,109,570.45</b>	<b>9,876,659.55</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>88,261,617.13</b>	<b>69,845,325.24</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>21,204,553.84</b>	<b>27,661,161.72</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	21,204,553.84	27,661,161.72
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,834,385.22	20,251,023.41
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,529,979.65	1,878,203.54
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	957,219.48	1,192,183.69
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	277,490.95	313,675.29
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,605,478.54	4,026,075.78
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>98,562.81</b>	<b>90,387.02</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	98,562.81	90,387.02
120002	Хүүгийн орлого	73,996.82	69,454.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,307.84	9,157.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,845.84	8,685.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	462.00	472.00

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

120009	Бусад орлого	13,258.15	11,775.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>66,958,500.47</b>	<b>42,093,776.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	307,200.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	307,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>25,744.00</b>	<b>8,606.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300.00	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,444.00	3,606.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>66,297,730.87</b>	<b>41,034,081.80</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,297,730.87	41,034,081.80
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>635,025.60</b>	<b>743,888.70</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	635,025.60	743,888.70
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>87,168,123.25</b>	<b>63,297,224.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>87,168,123.25</b>	<b>63,297,224.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>889,651.11</b>	<b>973,566.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>445,960.82</b>	<b>526,753.02</b>
210101	Үндсэн цалин	339,163.17	380,556.27
210102	Нэмэгдэл	97,440.33	117,663.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,357.32	20,256.00
210104	Урамшуулал	-	8,277.38
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,009.39</b>	<b>66,360.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,162.08	44,421.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,714.68	5,487.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,768.32	4,386.41
210204	Ажилгүйдлийн даатгал	940.65	1,094.94
210205	Эрүүл мэндийн даатгал	9,423.65	10,969.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,251.08</b>	<b>37,610.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,710.50	2,719.36
210302	Түлш, халаалт	27,507.38	31,353.26
210303	Цэвэр, бохир ус	3,033.20	3,537.46
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,108.30</b>	<b>29,213.82</b>
210401	Бичиг хэрэг	6,088.10	5,945.90
210402	Тээвэр, шатахуун	7,115.20	11,216.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,641.30	4,614.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,263.70	7,436.37
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,929.20</b>	<b>6,476.84</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,496.94
210604	Урсгал засвар	3,929.20	979.90
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,125.30</b>	<b>1,360.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,125.30	1,360.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,641.80</b>	<b>45,115.92</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,997.90	28,123.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	600.00	698.01
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62.10	59.90
210807	Газрын төлбөр	300.00	268.90
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,657.97	6,287.94
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,323.83	8,677.97
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>278,625.23</b>	<b>260,676.58</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,789.50	2,053.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	258,835.73	258,623.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,278,472.13</b>	<b>62,323,658.49</b>

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	46,581,890.10	56,769,429.90
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	46,542,549.20	56,719,136.92
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,403.00	15,629.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,937.90	34,663.98
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	39,696,582.04	5,554,228.59
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,696,582.04	5,554,228.59
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,093,493.88</b>	<b>6,548,100.34</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	6,840.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	6,840.00	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,149.51
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	1,149.51
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	6,840.00	(1,149.51)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,100,333.88</b>	<b>6,546,950.83</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>88,270,574.72</b>	<b>66,835,313.49</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>21,170,515.27</b>	<b>24,898,777.84</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	21,170,515.27	24,898,777.84
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,808,871.71	18,101,793.96
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,527,226.79	1,580,664.86
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	955,425.87	936,210.94
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	277,893.83	267,290.28
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,601,097.07	4,012,817.80
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>153,769.84</b>	<b>187,285.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	153,769.84	187,285.56
120002	Хүүгийн орлого	73,996.82	69,454.67
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	76,851.01	117,830.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,389.01	117,358.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	462.00	472.00
120009	Бусад орлого	2,922.02	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>66,946,289.60</b>	<b>41,749,250.10</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,744.00	8,606.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300.00	5,000.00

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,444.00	3,606.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>66,285,520.00</b>	<b>40,996,755.40</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,285,520.00	40,996,755.40
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>635,025.60</b>	<b>743,888.70</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	635,025.60	743,888.70
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>86,859,833.23</b>	<b>63,224,550.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>86,859,833.23</b>	<b>63,224,550.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>627,686.67</b>	<b>702,230.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>443,098.70</b>	<b>527,177.07</b>
210101	Үндсэн цалин	345,330.40	391,339.89
210102	Нэмэгдэл	87,041.10	105,172.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,727.20	22,387.20
210104	Урамшуулал	-	8,277.38
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,129.70</b>	<b>66,360.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,581.42	44,421.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,890.03	5,487.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,908.47	4,386.41
210204	Ажилгүйдлийн даатгал	975.64	1,094.94
210205	Эрүүл мэндийн даатгал	9,774.14	10,969.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,386.40</b>	<b>37,610.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,710.50	2,719.36
210302	Түлш, халаалт	29,642.70	31,353.26
210303	Цэвэр, бохир ус	3,033.20	3,537.46
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,353.30</b>	<b>26,711.45</b>
210401	Бичиг хэрэг	6,748.60	5,425.70
210402	Тээвэр, шатахуун	7,115.20	11,216.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,641.30	4,614.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,848.20	5,454.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,765.80</b>	<b>4,212.29</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,836.60	3,232.39
210604	Урсгал засвар	3,929.20	979.90
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>6,125.30</b>	<b>1,360.00</b>
210702	Дотоод албан томиллолт	6,125.30	1,360.00

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	36,037.97	36,745.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,997.90	28,123.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	600.00	698.01
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62.10	59.90
210807	Газрын төлбөр	300.00	268.90
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,657.97	6,287.94
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	720.00	308.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,789.50	2,053.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,789.50	2,053.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,232,146.56</b>	<b>62,522,319.78</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,535,564.52</b>	<b>56,968,091.19</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	46,450,788.23	56,833,893.55
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,403.00	15,629.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,435.39	83,904.66
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,937.90	34,663.98
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>39,696,582.04</b>	<b>5,554,228.59</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,696,582.04	5,554,228.59
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,410,741.50</b>	<b>3,610,763.41</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,410,741.50</b>	<b>3,610,763.41</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>817,852.87</b>	<b>2,228,594.36</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,228,594.36</b>	<b>5,839,357.78</b>

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	1,183,752.75	1,724,152.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	8,239.75	8,239.75
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>320,944.66</b>	<b>219,454.71</b>	<b>1,191,992.50</b>	<b>1,732,391.87</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,100,333.88	1,100,333.88
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	2,292,326.39	2,832,725.76
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	2,292,326.39	2,832,725.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	5,950.49	5,950.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,944.66	219,454.71	2,298,276.87	2,838,676.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,546,950.83	6,546,950.83
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	8,845,227.71	9,385,627.08

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	58,869,020.90	57,575,752.83	1,293,268.07	97.80
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	58,869,020.90	57,575,752.83	1,293,268.07	97.80
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	708,716.40	698,316.30	10,400.10	98.53
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	528,027.40	527,177.07	850.33	99.84
210101	Үндсэн цалин	392,187.60	391,339.89	847.71	99.78
210104	Урамшуулал	8,280.00	8,277.38	2.62	99.97
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,084.30	66,360.17	4,724.13	93.35
210201	Тэтгэврийн даатгал	49,963.30	44,421.49	5,541.81	88.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,280.30	5,487.99	(207.69)	103.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,224.20	4,386.41	(162.21)	103.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,056.00	1,094.94	(38.94)	103.69
210205	Эрүүл мэндийн даатгал	10,560.50	10,969.34	(408.84)	103.87
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37,880.80	37,610.08	270.72	99.29
210301	Гэрэл, цахилгаан	2,776.80	2,719.36	57.44	97.93
210302	Түлш, халаалт	31,503.40	31,353.26	150.15	99.52
210303	Цэвэр, бохир ус	3,600.60	3,537.46	63.14	98.25

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,109.60	23,105.45	4.15	99.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,619.10	4,614.95	4.15	99.91
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,214.70	4,212.29	2.41	99.94
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,232.40	3,232.39	0.01	100.00
210604	Урсгал засвар	982.30	979.90	2.40	99.76
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,362.70	1,360.00	2.70	99.80
210702	Дотоод албан томилолт	1,362.70	1,360.00	2.70	99.80
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	40,981.00	36,437.94	4,543.06	88.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,125.30	28,123.19	2,002.11	93.35
210803	Даатгалын үйлчилгээ	700.00	698.01	1.99	99.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350.00	59.90	290.10	17.11
210807	Газрын төлбөр	300.00	268.90	31.10	89.63
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,505.70	6,287.94	2,217.76	73.93
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,055.90	2,053.30	2.60	99.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,055.90	2,053.30	2.60	99.87
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	58,160,304.50	56,877,436.53	1,282,867.97	97.79
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	58,160,304.50	56,877,436.53	1,282,867.97	97.79
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	58,116,757.70	56,833,893.55	1,282,864.15	97.79
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,882.50	8,879.00	3.50	99.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,664.30	34,663.98	0.32	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	58,869,020.90	20,973,786.86	37,895,234.04	35.63
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	7,384,261.60	-	7,384,261.60	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	7,384,261.60	-	7,384,261.60	-
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	51,484,759.30	20,953,673.88	30,531,085.42	40.70
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	51,484,759.30	20,953,673.88	30,531,085.42	40.70
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	20,112.99	(20,112.99)	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,639.82	(19,639.82)	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	473.17	(473.17)	0
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	2,228,594.36	(2,228,594.36)	0.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	5,839,357.78	(5,839,357.78)	0.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,606.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,606.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,606.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,606.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,606.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>8,606.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,606.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,606.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 20-оос 2021 оны 03 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Н.Бүнчинсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх"-д оршино.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2020 оныг "Нэг бүртгэл-нэг хяналт"-ын жил болгон зарласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1.Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2020 оны 01 дүгээр сарын 03-ний өдрөөс цагт 2500 төгрөг сард 420.000 төгрөгөөр тогтоосон.

2.Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль батлагдсан

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.6.2-т нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эх энэ хуулийн 19 дүгээр зүйлд жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн бол төлөх шимтгэлийн 50 хувийг өөрөө, 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, мөн зүйлийн 3.6.3-т бусад эхийн төлбөл зохих шимтгэлийг 50 хувийг төрөөс, 50 хувийг эх өөрөө төлнө.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт " Төрүүлсэн болон гурав хүртэлх настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл өсгөсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчилж авсан эх бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр нэг жил зургаан сар нэмж тооцно.

5.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд дараах өөрчлөлүүд орсон. Үүнд:

- ✓ Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно
- ✓ Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно.
- ✓ Корона вируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон

болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгоно.

- ✓ Хуулийн энэ зохицуулалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сайн дураар даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн 12 сарын орлогын дунджаас 100 хувиар тооцон олгож эхэллээ. /Өмнө нь 70 хувиар тооцдог байсан/
- ✓ Ажил хөдөлмөр эрхэлж байсан буюу албан журмын даатгуулагч эхэд хуульд заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлэх бүрт жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.
- ✓ Тэтгэврийг даатгуулагчийн шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн дотроос дурын дараалсан 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаас тогтоож байсныг 7 жилийн буюу 84 сарын дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Хуулийн энэхүү зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2020 оноос эхлэн тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан иргэдэд хамаарна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Хяналт, шалгалт, дотоод аудитын газар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасгаар дамжуулан 2021 оны 01 дүгээр сард цахимаар хэлтсийн 2020 оны шатахуун, үнэт цаасны зарцуулалт болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байгаа даатгуулагчийн ажлын байрыг хадгалах зорилгоор төрөөс олгосон ажилгүйдлийн дэмжлэгт аудит хийсэн ба шалгалтаар зөрчил илрээгүй байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.05 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 74467.0 сая төгрөгийн 0.05 хувь буюу 37.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 63298.4 сая төгрөгийн 0.05 хувь буюу 31.6 сая төгрөг болж

төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 5.6 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас тооцсон, тайлант жилийн зардал өмнөх оноос буурсантай холбоотой байна.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2228.6 сая, эцсийн үлдэгдэл 5839.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3610.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	2228.6	5839.4	3610.8	100%
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>2228.6</b>	<b>5839.4</b>	<b>3610.8</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1.2 сая төгрөг нь аймгийн Төрийн сангийн 100030090501 тоот ахмадын сангийн дансны үлдэгдэл, 5838.2 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байгаа үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 3.610.8 сая төгрөгөөр өссөн нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2021 оны 1 дүгээр сарын тэтгэврийн санхүүжилт 3.200.0 сая төгрөгийн санхүүжилт орж ирснээр үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 431.6 сая, эцсийн үлдэгдэл 3823.8 сая төгрөг болж, 3392.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага	393.9	448.6	54.7
Татаас, санхүүжилтийн авлага		3302.5	3302.5
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	37.7	72.7	35.1
Зээлийн авлага			
<b>Дүн</b>	<b>431.6</b>	<b>3823.8</b>	<b>3392.2</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

#### **Нийгмийн даатгалын сан:**

Төлбөр үйлчилгээний авлага нь оны эхний үлдэгдэл 393,8 сая төгрөг оны эцсийн үлдэгдэл 448,5 сая төгрөг тайлант онд 54,7 сая төгрөгөөр өссөн байна. 2020 онд дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /COVID/ цар тахлын үед аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа зогсонги, санхүүгийн чадамж буурснаар нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаанд нь төлөөгүйгээс үүсэн авлага болно.

Коронавируст халдвар /COVID/ үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч

болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ий 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг нийт 383 аж ахуй, нэгж байгууллагыг 2478.2 сая, сайн дурын 6555 даатгуулагчийг 2703.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлсөн ба аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа даатгуулагчийн ажлын байрыг хадгалах зорилгоор 49 байгууллагад 307,2 сая төгрөгийг олгож, нийт 5489.2 сая төгрөгийг улсын төсвөөс авах авлага үүссэнээс тайлант онд 2186.7 сая төгрөгийн санхүүжилт авч авлагыг бууруулан оны эцэст улсын төсвөөс авах 3302.4 сая төгрөгийн авлагатай гарчээ

Байгууллагаас авах авлага оны эхний үлдэгдэл 37.7 сая төгрөг оны эцсийн үлдэгдэл 68.8 сая төгрөг болж 35.1 сая төгрөгөөр өссөн нь 2020 оны 12 дугаар сард сайн дурын даатгуулагч эхийн тэтгэмжийн даатгалын сангаас төлөх 37.5 сая төгрөгийг данс андуурч хийснээр тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сангийн хооронд 38.1 сая төгрөгийн авлага, өглөг үүссэн ба 2021 оны 02 дугаар сард данс хооронд гүйлгээ хийж залруулсан байна.

### Нийгмийн даатгалын хэлтэс:

Хувь хүнээс авах авлагын оны эхний үлдэгдэл 3.9 сая төгрөг оны эцэст 3.9 сая төгрөг байна. Уг авлага нь даргаар ажиллаж байсан Ц.Сэмжиддоржтой холбоотой авлага ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа болно.

#### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 0.4 сая төгрөг байсан ба ажилтны цалингийн урьдчилгааг барагдуулж, оны эцэст үлдэгдэлгүй байна.

*Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.4	0	-0.4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
<b>Дүн</b>	<b>0.4</b>	<b>0</b>	<b>-0.4</b>

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

#### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 20.8 сая, эцсийн үлдэгдэл 15.7 сая төгрөг болж, 5.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	1.0	0.4	-0.5
Аж ахуйн материал	8.7	9.6	0.9
Сэлбэг хэрэгсэл	4.2	2.0	-2.3
Бусад хангамжийн материал	6.9	3.7	-3.2
<b>Дүн</b>	<b>20.8</b>	<b>15.7</b>	<b>-5.1</b>

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 5.1 мянган төгрөгөөр буурсан нь, бичиг хэргийн материал 0.5, сэлбэг хэрэгсэл 2.3 сая, бусад хангамжийн материал 3.2 сая төгрөгөөр тус тус буурч, аж ахуйн материал 0.9 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 860.2 сая, эцсийн үлдэгдэл 832.9 сая төгрөг болж, 27.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	466.8	466.8	0.0
Авто-тээврийн хэрэгсэл	90.0	90.0	0.0
Машин тоног төхөөрөмж (компьютер)	152.6	141.8	-10.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	79.9	63.5	-16.4
Програм хангамж	3.7	3.7	0.0
Бусад биет бус хөрөнгө	67.2	67.2	0.0
<b>Дүн</b>	<b>860.2</b>	<b>832.9</b>	<b>-27.2</b>

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020.07.01-ны өдрийн 5/1204 дугаар тушаалаар 6.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Нийгмийн Даатгалын Ерөнхий газрын Мэдээлэл технологийн төвөөс 22.6 сая төгрөгийн компьютер техник хэрэгслийг тус тус шилжүүлэн авсан, 0.4 сая төгрөгийн тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020.12.28-ны өдрийн "Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" 773 тогтоолыг үндэслэн Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2020.12.31-ний өдрийн А/161 дугаар тушаалаар 56.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 276.8 сая, эцсийн үлдэгдэл 491.0 сая төгрөг болж, өмнөх оноос өр төлбөр 214.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>276.8</b>	<b>491.0</b>	<b>214.2</b>	<b>100</b>
Бараа үйлчилгээний зардлын өглөг	121.2	63.2	-58.0	12.9
Байгууллагад төлөх өглөг	0.3	0.0	-0.3	
НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	0.2	0.0	-0.2	
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	155.2	427.9	272.7	87.1
<b>Нийт дүн</b>	<b>276.8</b>	<b>491.0</b>	<b>214.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 63.2 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөг, 427.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөг нь тайлант хугацаанд тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой 98.8 сая төгрөг бусад өглөг 1.4 сая төгрөгийн өглөгийн барагдуулж, 37.1 сая төгрөг шинээр нэмэгдсэн байна.

Энэ нь тэтгэврийн даатгалын сангаас тэтгэмжийн даатгалын сангийн сайн дурын даатгуулагч эхийн төлөх шимтгэлийн өглөг байна.



Засгийн газрын байгууллага, бусад бүх шатны төсөв эхний үлдэгдэл 155,1 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 427,8 сая төгрөг болж 272,7 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь сайн дурын даатгуулагчийн гэрээ он дамнаж хийсэнтэй холбоотой өглөг 272.7 сая төгрөгөөр өсгөсөн байна. Мөн Засгийн газрын 140-р тогтоол хөнгөлөлт чөлөөлөлт 6555 даатгуулагч хамрагдсантай холбоотой ихэнх даатгуулагч жилээр гэрээ хийж төлсөнтэй холбоотой өглөг байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2832.7 сая, эцсийн үлдэгдэл 9385.6 сая төгрөг болж, 6552.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320.9	320.9	0.0	3.4
Хуримтлагдсан үр дүн	2292.3	8845.2	6552.9	94.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219.5	219.5	0	2.3
<b>Дүн</b>	<b>2832.7</b>	<b>9385.6</b>	<b>6552.9</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9385.6 сая төгрөг болж 6552.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого төлөвлөөгүй бөгөөд тайлант хугацаанд нийт 21.1 сая төгрөгийн орлого оруулсан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны орлогоор 19.6 сая төгрөгийг оруулснаас хугацаандаа төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийн алданги 8.6 сая, хяналтын байцаагчаас тогтоосон торгуулийн орлого 0.5 сая төгрөгийг оруулж, бусад авлагын 10.5 сая төгрөгийг барагдуулж, орлогоор тайлагнасан байна.

Туслах үйл ажиллагааны иргэдэд үйлчилсний архивын лавлагааны орлогоор орсон 0.5 сая төгрөгийг бүртгэсэн байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжид 56840.1 сая, хэлтсийн үйл ажиллагааны зардалд 734.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар зардлын данстай холбоотой 1.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

### **Аудитын илрүүлэлт:**

Дулаан үйлдвэрлэгч “Хөвших од” ХХК-тай сард 3.7 сая төлөхөөр 2020.01.23-ний өдрийн 08 дугаартай гэрээ байгуулсан бөгөөд тухайн жил 8 сар халааж 29.6 сая төгрөг төлөхөөр байхад 31.3 сая төгрөг төлж 1.7 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Сангийн орлого бүрдүүлэлт

НДҮЗ-ийн 2020.12.18-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор 2020 оны төсвийн хуваарь өөрчлөлт оруулж, санд 17904.43 сая төгрөг төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр сангийн орлогын төлөвлөгөөг сан тус дээр давуулан биелүүлж, нийт орлогыг 117.14 хувиар давуулан биелүүлж, 20973.31 сая төгрөгийг оруулсан байна.

Хавсралт №8. Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	15,569.86	18,168.59	(2,598.73)	116.69
2	Тэтгэмжийн даатгалын сан	1,302.29	1,586.12	(283.83)	121.79
3	ҮОМШӨД-ын сан	778.51	938.45	(159.94)	120.54
4	Ажилгүйдлийн даатгалын сан	253.77	280.16	(26.39)	110.40
	ДҮН	17,904.43	20,973.31	(3,068.89)	117.14

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

**Харилцах дансны** чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд жилийн 5.5 хувийн хүүтэй хадгалуулах гэрээг арилжааны банкнуудтай байгуулж, 2020 онд 69.5 сая төгрөгийн хүүгийн орлого орсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Хавсралт №9. Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Банкны нэр	Жилийн хүү /хувиар/	Нийт хүүгийн орлого
1	Хаан банк	5.5%	51.01
2	Төрийн банк	5.5%	16.70
3	Хас банк	5.5%	0.01
4	Голомт банк	5.5%	1.73
	ДҮН		69.45

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

### Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 18666.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 55275.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс орлогыг 4706.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 23373.5 сая төгрөгөөр, зардлыг 2473.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 57749.2 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн хуваарьт 2020 оны 4, 6, 9 дүгээр саруудад өөрчлөлт оруулж, оны 12 дугаар сард орлогыг 5469.0 сая төгрөгөөр бууруулж, 17904.4 сая төгрөгөөр, зардлыг 1119.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 58869.0 сая төгрөгөөр баталжээ.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 6 арга хэмжээний зардалд зориулан 58869.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас сангийн үйл ажиллагааны зардалд 58125.1 сая, Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардалд 743.8 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Тайлант онд НДЕГ-аас тэтгэврийн даатгалын сангийн санхүүжилтээр 39855.3 сая, тэтгэмжийн даатгалын сангийн санхүүжилтээр 647.0 сая, ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүжилтээр 494.5 сая, нийт 40996.8 сая төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын сангийн орлогоор 20973.3 сая төгрөгийн орлого оруулж, 56840.0 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн зардалд олгосон байна.

Хавсралт 10. Сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Даатгуулагчийн тоо
---	---------------	------------	-----------	-------	------	--------------------

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1	Тэтгэврийн даатгалын сан	54,605.99	53,534.15	1,071.83	98.04	12,710
2	Тэтгэмжийн даатгалын сан	2,320.28	2,293.00	27.28	98.82	2,061
3	ҮОМШӨД-ын сан	145.36	158.64	(13.28)	109.13	32
4	Ажилгүйдлийн даатгалын сан	1,053.51	854.27	199.23	81.09	314
	<b>ДҮН</b>	<b>58,125.13</b>	<b>56,840.06</b>	<b>1,285.07</b>	<b>97.79</b>	<b>15,117</b>

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

ҮОМШӨД-ын сангийн батлагдсан зардлыг 13.2 сая төгрөгөөр хэтрүүлж, дутагдсан эх үүсвэрийг тэтгэврийн даатгалын сангаас зарцуулсан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 -т заасны дагуу тэтгэвэр, тэтгэмжийг олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 11. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /сая төгрөгөөр/

II	80101-ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,125.13	56,840.06	1,285.07	97.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,125.13	56,840.06	1,285.07	97.79
2132	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,116.76	56,833.89	1,282.86	97.79
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8.37	6.17	02.21	73.64

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс өөрийн орлогын төлөвлөгөөгүй ажилладаг бөгөөд НДЕГ-аас хэлтсийн үйл ажиллагаанд 743.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 734.5 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 8.5 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 12. Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /сая төгрөгөөр/

II	АРГА ХЭМЖЭЭ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
	<b>80101-ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>743.89</b>	<b>735.69</b>	<b>08.20</b>	<b>98.90</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743.89	735.69	08.20	98.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670.22	664.03	06.19	99.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528.03	527.18	00.85	99.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71.08	66.36	04.72	93.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37.88	37.61	00.27	99.29
2104	Хангамж, бараа материалын зардал	23.11	23.11	00.00	99.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4.21	4.21	00.00	99.94
2107	Томилолт, зочны зардал	1.36	1.36	00.00	99.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.48	2.15	00.33	86.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2.06	2.05	00.00	99.87
	<b>80103-ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>06.14</b>	<b>6.01</b>	<b>00.13</b>	<b>97.88</b>
	<b>2.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6.14</b>	<b>6.01</b>	<b>00.13</b>	<b>97.88</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6.14	6.01	00.13	97.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6.14	6.01	00.13	97.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6.14	6.01	00.13	97.88
	<b>80205-МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>02.25</b>	<b>02.25</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
	<b>3.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>02.25</b>	<b>02.25</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	02.25	02.25	00.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	02.25	02.25	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	02.25	02.25	00.00	100.00
	<b>80213- ӨМГӨӨЛӨЛ ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН ХӨТӨЛБӨР</b>	<b>0.69</b>	<b>0.68</b>	<b>00.01</b>	<b>98.68</b>

**Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	<b>4.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.69	0.68	00.01	98.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.69	0.68	00.01	98.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.69	0.68	00.01	98.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.69	0.68	00.01	98.68
	<b>80224-ЗӨВЛӨЛ, ХОРОО КОМИССЫН ГИШҮҮД</b>	<b>21.04</b>	<b>19.18</b>	<b>01.86</b>	<b>91.15</b>
	<b>5.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	21.04	19.18	01.86	91.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21.04	19.18	01.86	91.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21.04	19.18	01.86	91.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21.04	19.18	01.86	91.15
	<b>80802-АЖИЛ ОЛГОГЧООС ОЛГОХ ТЭТГЭМЖ</b>	<b>34.66</b>	<b>34.66</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
	<b>6.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	34.66	34.66	00.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34.66	34.66	00.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34.66	34.66	00.00	100.00
2132	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	34.66	34.66	00.00	100.00
	<b>80813-ХУУЛЬД ЗААСАН ҮНДЭСЛЭЛЭЭР</b>	<b>2.19</b>	<b>2.19</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
	<b>7.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2.19	2.19	00.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2.19	2.19	00.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2.19	2.19	00.00	100.00
2132	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2.19	2.19	00.00	100.00
	<b>80820-БУСАД ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ</b>	<b>6.70</b>	<b>6.69</b>	<b>00.00</b>	<b>99.95</b>
	<b>8.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	6.70	6.69	00.00	99.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6.70	6.69	00.00	99.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6.70	6.69	00.00	99.95
2132	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	6.70	6.69	00.00	99.95

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс төрийн албан хаагчдад олгох орон сууцны дэмжлэг 5.0 сая, Нийгмийн даатгалын Ерөнхий газраас корновирус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 3.6 сая нийт 8.6 сая төгрөгийн орлого төвлөрч зарцуулсан байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**Нийгмийн даатгалын хэлтэс:**

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг үнэн зөв байршуулсан эсэхийг шалгахад тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 11 сар, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 11 сар, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 11 сард тус тус хугацаа хоцроож байршуулсан байна

Хүснэгт 11. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	11	11	
2	Хагас жил	4	4	4	
3	Улирал бүр	1	4	4	
4	Сар бүр	3	36	36	
5	Тухай бүр	8	96	93	3
	Нийт	27	151	148	3

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шилэн дансны цахим хуудас

**Нийгмийн даатгалын сан:**

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	1, 3 дугаар улирлын төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
4	Сар бүр	3	36	35	1	1 дүгээр сарын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар
5	Тухай бүр	8	96	94	2	1 дүгээр сард худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, 5 дугаар сард тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт
	Нийт	27	151	146	5	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шилэн дансны цахим хуудас

**3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 13.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 0.35 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 16.5 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №12. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	4	13.31	4	13.31			100
Албан шаардлага	1	0.35	1	0.35			100
Зөвлөмж	5	16.53	4	12.62	1	3.91	76.3
Нийт	10	30.19	9	26.28	1	3.91	87.0

Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2020.05.29-ны өдрийн 194 дүгээр албан бичгээр аудитын зөвлөмжийг хариуг ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг шалгаж үзэхэд хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Сэмжиддоржтой холбоотой 3.9 сая төгрөгийг авлагыг барагдуулаагүйтэй холбоотой байна. Дээрх авлагыг шүүхэд өгсөн шүүхийн шийдвэр гарсан байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитаар нийт 7.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1.7 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

#### Төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт

##### 3.9.1. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Дулаан үйлдвэрлэгч “Хөвших од” ХХК-тай сард 3.7 сая төлөхөөр 2020.01.23-ний өдрийн 08 дугаартай гэрээ байгуулсан бөгөөд тухайн жилд 8 сарын хугацааны халаалтын үйлчилгээний хөлсөнд 29.6 сая төгрөг төлөхөөр байхад 31.3 сая төгрөг төлж 1.7 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, “Хөвших Од” ХХК, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын хооронд байгуулсан Дулаанаар хангах гэрээний 4 дүгээр заалтад заасан халаалтын сард төлөх тооцоог зөрчсөн ба санхүүгийн тайлагналын Үнэн зөв байх, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Хөвших од” ХХК-аар 1.7 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

##### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дэлхий нийтэд гарсан Ковид-19 цар тахалтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт авсан 383 аж ахуйн нэгж байгаа бөгөөд аймгийн дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага, өрхийн эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгч нөхөрлөлүүд багтсан байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээ хэвийн, төсвөөс авах санхүүжилт, халаалтын үйлчилгээний төлбөрөө бүрэн авч хэвийн үйл ажиллагаа явуулсан тул дараагийн аудитаар энэ асуудлыг тодруулан шалгах шаардлагатай байна. Мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байгаа даатгуулагчийн ажлын байрыг хадгалах зорилгоор төрөөс олгосон ажилгүйдлийн дэмжлэгийг дараагийн аудитаар тодруулан үзэх шаардлагатай байна.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

**3.1.1 Илрүүлэлт:** Нярвын тайланг анхан шатны баримттай тулган шалгахад хөрөнгийн шинж чанартай цаашид ашиглагдах хөрөнгүүдийг шаардах хуудсаар шууд зарлага болгосон байна. Үүнд сэлбэг хэрэгслийн материалаас 2.6 сая, аж ахуйн материалаас 2.6 сая, бичиг хэргийн материал 0.4 сая, нийт 5.6 сая төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл: Хөрөнгө дутагдах

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Цаашид ашиглах хөрөнгийн шинж чанартай 5.6 сая төгрөгийн материалуудыг хөрөнгөнд бүртгэж, ажиллагсдын хөрөнгийн картаар хяналт тавьж, ашиглалтгүй болсон тохиолдолд байгууллагын даргын тушаалаар акталж устгаж байх.

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

##### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

##### 3.1.2 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын сангийн 5 мэдээлэл, нийгмийн даатгалын хэлтсийн 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хоцроож мэдээлсэн, шилэн дансны мэдээллийг шалгахад нийгмийн даатгалын сангийн 12 дугаар сард мэдээлэх төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй илгээж хадгалсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

**3.1.2 Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах, нийгмийн даатгалын сангийн 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийг нөхөн мэдээлэх.

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b> 2021.03.25	<b>Аудитын нэр:</b>	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b> БНА-2021/21/СТА-ТТЗ		
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс			<b>Сая төгрөгөөр</b>	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Дулаан үйлдвэрлэгч "Хөвших од" ХХК-тай сард 3.7 сая төлөхөөр 2020.01.23-ний өдрийн 08 дугаартай гэрээ байгуулсан бөгөөд тухайн жил 8 сар халааж 29.6 сая төгрөг төлөхөөр байхад 31.3 сая төгрөг төлж 1.7 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.	1.7	Төлбөрийн акт тогтоох	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Д.Мөнхбат С.Хонгорзул
2	Хөрөнгийн шинж чанартай цаашид ашиглагдах сэлбэг хэрэгслийн материалаас 2.6 сая, аж ахуйн материалаас 2.6 сая, бичиг хэргийн материал 0.4 сая, нийт 5.6 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан байна	5.6	Зөвлөмж өгөх	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Д.Мөнхбат С.Хонгорзул
3	Нийгмийн даатгалын сангийн 5 мэдээлэл, нийгмийн даатгалын хэлтсийн 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хоцроож мэдээлсэн, нийгмийн даатгалын сангийн 12 дугаар сард мэдээлэх төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй хоосон хадгалсан байна.	0	Зөвлөмж өгөх	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Д.Мөнхбат С.Хонгорзул
<b>Дүн</b>		<b>7.3</b>			

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА 2021.03.25

Н.БҮНЧИНСҮРЭН 2021.03.25

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Б.МӨНХБАТ 2021.03.25

БНА-2021/21/СТА-ТТЗ

